



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/172

Хажуу шинэ-Ус

Бүх нийтийн цэвэрлэгээ зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9. 4.12, 9.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хаврын бүх нийтийн цэвэрлэгээг 2024 оны 07 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.2024 оны 07 дугаар сарын 16-ний өдөр албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүр орчны 50 метр газраа цэвэрлэх, 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдөр албан байгууллага аж ахуйн нэгж, иргэд нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын төвийн багийн Засаг дарга (Л.Батбаатар)-т үүрэг болгосугай.

3.Их цэвэрлэгээнээс гарсан үүсмэл хог хаягдлыг цаг хугацаанд нь тээвэрлэх ажлыг сумын төвийн багийн засаг даргатай хамтран зохион байгуулж ажиллахыг Санхүү албаны дарга (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Цэрэнчунт)-д даалгасугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож бүгд хамрагдахад анхаарч ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж), цагдаа (Б.Наранбаатар) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Б.ДАВААСҮРЭН



482401092